



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/125

Төмөрбулаг сум

Цэрэг татлагын комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 12, Аймгийн засаг даргын 2024 оны А/105 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд цэргийн албаны ээлжит татлагыг хариуцан зохион байгуулах комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга Г.Нямханд- ЗДТГ-ын дарга
Гишүүдэд- Д.Мэнджаргал-ЭМТ-ийн дарга
М.Нямдэлгэр-Соёлын төвийн дарга
н. Оюунбаатар - цагдаагийн хэсгийн цагдаа
Л.Амарбат-архив, бичиг хэргийн эрхлэгч
Ц.Доржготов- 1-р багийн засаг дарга
Ч.Цэдэвсүрэн-2-р багийн засаг даргын үүрэг гүйцэтгэгч
Л.Батсайхан- 3-р багийн засаг дарга
Д.Эрдэнэжаргал- 4-р багийн засаг дарга
Ш.Нацагдорж-5-р багийн засаг дарга
Д.Цэвэлсүрэн- насан туршийн боловсролын багш

2. Цэрэг татлагын ажлыг товлосон хугацаанд чанартай зохион байгуулж ажиллахыг комиссын дарга (Г.Нямханд)- д даалгасугай.

3. Цэргийн үүрэгтнүүдийг товлосон цаг хугацаа хожимдуулахгүй ирүүлэх ба тухайн үеийн бэлтгэл зохион байгуулалтыг бүрэн хариуцаж ажиллахыг багийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Цэрэг татлагын үеэр хийгдэх шинжилгээ болон эмнэлгийн үзлэг явуулахад ажиллах эмч, сувилагч болон техник хэрэгсэл, байрны бэлтгэл зохион байгуулалтын хангаж ажиллахыг ЭМТ-ийн дарга (Д.Мэнджаргал, соёлын төвийн дарга М.Нямдэлгэр) нарт үүрэг болгосугай.

5. Цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх, боловсролын судалгааг шинэчлэн гаргах ажлыг жил бүр чанартай зохион байгуулж, тайлан мэдээг хугацаанд нь ирүүлж байхыг ЭМТ-ийн дарга (Д.Мэнджаргал, ЕБС-ийн захирал Д.Мягмармаа) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ЭНХБАЯР

